| 6.1.1 | Эмийн зохистой хэрэглээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээ хэрэгжүүлнэ. | | - Сургалтын тоо - Хамрагдсан эмч мэргэжилтэн, үйлчлүүлэгчийн тоо | 350 эмнэлгийн ажилтан, 6180 иргэд | - Эмнэлгийн ажилтан 400 -6200 | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал Дэлхийн өдрийг тохиолдуулн “Үйлчлүүлэгчийн дуу хоолойг сонсьё” уриан дор өдөрлөгийг ӨЭМТ, 3 эмийн сантай хамтран зохион байгуулж, 21 эмнэлгийн ажилтан, 119 иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан. ДАТ КОНСАЛТИНГ ХХК-тай хамтран мансууруулах бодис, эм хэрэглэсэн хүнийг таних, шаардлагатай арга хэмжээг авах мэдлэг олгох сургалтад 38 эмч мэргэжилтэнг хамруулсан. Эмч, эмнэлгийн ажилтнуудын эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, Антибиотикийн мэдрэг чанар үзэж хэвших сургалт 4 удаа нийт 141 эмч, эмнэлгийн ажилтан, эмийн жор бичилтийн стандартаар 3 удаа сургалт явуулсан нийт 270 эмч, эмнэлгийн ажилчдад хамрагдсан.<br>Иргэд, хэвтэн эмчлүүлэгчдэд чиглэсэн эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор 2023 оны 02 сард хэвтэн эмчлүүлж байгаа иргэдэд эмийн зохистой хэрэглээний талаарх өдөрлөг 1 удаа, сургалт 3 удаа, аян 1 нийт 398 хүнд мэдээ, мэдээлэл өгсөн.<br>Монфа ХХК, Монголын диабетын холбоо хамтран чихрийн шижингийн эмийн эмчилгээ талаар сургалтыг 60 гаруй эмч мэргэжилтэн, 70 гаруй иргэдэд зохион байгуулж ажилласан. ЭМБ-дад Эмийн аюулгүй байдал аяныг зохион байгуулж ЭМГ, DBS телевизтэй хамтран Эмийн мэргэжилтэн мэдээлэл хүргэхэд цахим хандалт 6000, антибиотик эмийн зохистой хэрэглээ иргэдэд зориулан контент хийж цахим орчин байршуулан цахим орчинд байршуулан 3000 хандалт авсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1.2 | Эм зүйн салбарт мөрддөг стандартад үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангуулан ажиллана. | 400 мян | - Хамрагдсан байгууллага | -62 эмийн сан | -30 эмийн сан, -7 ЭХНБ | Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2016 стандартын хэрэгжилт,Эмийн жорын маягт, жор бичилт MNS5376:2016 стандартын хэрэгжилт, Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журмын хэрэгжилт хангуулж ажиллах зорилгоор Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг томилогдон тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сангуудад дэмжлэгт хяналт үнэлгээг 37 эмийн сан, ЭХХБ-д хийж, 11 төрлийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан. | 100 |
| 6.1.3 | Антибиотик эмэнд тэсвэржилт үүсэхээс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж, судалгаа хийж үр дүнг тооцон ажиллана. | - | -Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан иргэдийн тоо<br>-судалгааны үр дүн | 116 эмнэлгийн ажилтан, 1681 иргэд үйлчлүүлэгч<br>-Макролид бүлэг-45.9%<br>Цефалоспорины бүлэг 38.3%<br>Аминогликозидын бүлэг 77.1% | -Эмнэлгийн ажилтан 200 Иргэд 1800<br>-Антибиотекийн тэсвэржилтийн 5%-иар буулгах | Антибиотик тэсвэржилт үүсэхээс сэргийлье!<br>Бичил биетний талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх "ДЭЛХИЙН 7 ХОНОГ" зохион байгуулж, сургалтад 218 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>Эрүүл мэндийн газар, Эм холбоо, DBS телевиз хамтран иргэдийн эмийн зохистой хэрглээний талаарх эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор цахим зөвлөмж, контент хийж цахим орчин байршуулан ажилласан иргэдэд зориулан контент хийж цахим орчин байршуулан хандалт 3000<br>Антибиотикийн тэсвэржилтийн судалгаа хийсэн үр дүн: Антибиотик мэдрэг чанар 378 хүнд тодорхойлсон.<br>Ялгагдсан бактерийн 11 бүлэг хүрээ<br>- Грамм эерэг коккийн хувьд ампициллинд 88%,<br>- гентамицинд 55%,<br>- эритромицинд 82%, ципрофлоксацинд 27%, цефазолинд 30%, левомицетинд 45%, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хинолины бүлэг-63.2% Пенциллины бүлэг-23.2% байна | | нитрофурантоинд 40%, триметопримд 75% тэсвэржсэн байна. Грам сөрөг савханцар Pseudomnonas нь ампициллинд 100% тэсвэржилттэй байна. | |
| 6.1.4 | ЭМБ-уудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдалд тогтмол хяналт тавьж ажиллана | - | Нөөц бүрдүүлэлт | 1-2 сарын нөөцтэй | 1-3 сарын нөөц | ЭМБ-ын тендер худалдан авалтыг гэрээний дагуу татан авалтад 4 удаа хяналт тавьж ажилласан. 2023 оны 3-р улирлын байдлаар Ерөнхий гэрээгээр 16 байгууллагатай 20 гэрээгээр 188,561,739 эм бараа татан авалт хийж эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Мөн сар бүр Burtgel.mohs.mn программд хяналт тавьж ажиллаж байна. ЭМБ-ууд 1 сарын нөөцтэй байна. ЭМСайдын 2020 оны 12-р сарын 25-ны өдрийн А/265 тоот тушаал 9-р жагсаалтын дагуу зайлшгүй шаардлагатай эмийн ээлэх хувь 92%-иар эмнэлгийн тасаг нэгжүүдийг ханган ажиллаж байна. | 100 |
| **Чиглэл 6**<br>**1 зорилт, 4 арга хэмжээний дундаж** | | | | | | | **100%** |
| **Чиглэл 7. Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийг нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглана.** | | | | | | | |
| **Зорилт 7.1. Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх** | | | | | | | |
| 7.1.1 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд алсын зайн оношилгоо, зөвлөгөө, мэдээлэл солилцох (теле медицин) тусламж үйлчилгээг нэмэгдүүлж, | - | -телемедицины тусламж үйлчилгээ авсан | -алсын зайн оношилгоо 680 удаа | -Шаардлагатай тохиолдол | Нэгдсэн эмнэлгийн эх, нярай зайн оношилгооны төвийг ДЭМБ санхүүжилтээр багаж тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл хэрэгжүүлэхээр ажлын хэсэг судалгаа хийсэн.<br>Эмнэлгийн тусламж үйлчилгээнд Телемедицин | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатлалд хэрэгжүүлж ажиллана. | | иргэдийн тоо | | бүрт | алсын зайн оношилгоог телеграм, viber, Zoom, MnCardio, mohs.da.gov.mn, Axis Hospital Karte зэрэг программыг ашиглан 456 зөвлөгөө мэдээллийг 341 удаа солилцож СЭМТ-тэй 10 удаа зөвлөгөө мэдээлэл солилцон тусламж үйлчилгээний хамрах хүрээг УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ ЭСҮТ,ЦСҮТ, СЭМТ зэрэг эмнэлгүүдтэй хамтран хамрах хүрээг нэмэгдүүлсэн.<br><br>**Үр дүн:** 4 программаар зайн оношлогооны үйлчилгээнд 456 зөвлөгөө мэдээллийг 341 удаа солилцсон. | |
| 7.1.2 | Эрүүл мэндийн цахим мэдээллийн сангаар иргэдийг эрт илрүүлэгт хамруулж, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ. | - | - Цахимаар эргэн дуудах тогтолцоонд хамрагдсан иргэд | Хөхний эрт илрүүлэг үзлэгт **28249** буюу 89.7% Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт **4140** буюу 60.9% | Хөхний эрт илрүүлэг үзлэгт **90**% Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт 61% | 2020 оны 12 дугаар сарын 31 ны өдрийн А/641 тоот тушаалаар “Умайн хүзүүний хорт хавдрын цогц хяналтын заавар”-ыг шинэчлэх тухай тушаалын 2.3 заалтын дагуу “Умайн хүзүүний хорт хавдрын илрүүлгийн бүртгэл мэдээлэл, дуудах-эргэн дуудах тогтолцоог хэрэгжүүлэх, мэдээлэх үйл ажиллагааг тусган зааварласан.<br><br>2023 оны 12 сарын байдлаар:<br><br>• Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 20-оос дээш насны **31500** эмэгтэй хамрагдахаас **29849** буюу 94.7%-ийн хамрагдалтай. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 хувиар өссөн байна. Эмнэл зүйн үзлэгээр эерэг өөрчлөлттэй гарсан 31. 13А маягтаар 2-р шатлалд илгээсэн 31. Эмчилгээнд-31, эрт илрүүлгээр оношлогдсон хавдар-1.<br>• Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 30-60 насны нийт **6795** эмэгтэй хамрагдахаас **4994** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | буюу 73.5% -ийн хамрагдалтай. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.6 хувиар өссөн байна. Хавдрын урьдал илэрсэн 183, байран өмөн илэрсэн 2. үрэвслийн эсрэг эмчилгээ 176 хүнд хийгдсэн байна. Эрт илрүүлгээр хорт хавдар оношлогдсон-7.<br>• УХХХ-ын илрүүлгийн дуудах-эргэн дуудах үйл ажиллагаанд **www.cancer-screening.gov.mn** цахим бүртгэлийн үндэсний систем хэрэгжиж, 2023 оны эхний 12 сард нийт умайн хүзүү-2727 буюу 54.6%, хөх-15026 буюу 50.3% иргэний мэдээллийг, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт орсон 4994 иргэнийг EXCEL программд бүртгэн мэдээллийн сан үүсгэн ажилласан. УХХХ-ын илрүүлгийн дуудах-эргэн дуудах үйл ажиллагаанд оролцох эрх бүхий эрүүл мэндийн 9 байгууллагын 79 эмч, мэргэжилтнүүдийн хандах эрхийг олгосон.<br>• Хавдрын шинэ өвчлөл 249, нас баралт 161 бүртгэгдсэн. Эрт үедээ 19.3% , хожуу оношилогдсон 80.7% байна. | |
| 7.1.3 | Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг | - | Мэдээ өгөлтийн хувь | 92 | 95 | ЭМС-ын 611 тоот тушаалын дагуу ЭМБ-ын мэдээг сар бүрийн 3-ны дотор цуглуулаж H-info 3 болон цахим эрүүл мэнд программд шивж, мэдээллийн үнэн зөв байдалд тулгалт хийж эрүүл мэндийн хөгжлийн төвд 5 удаа цахимаар илгээн, эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг эргэн мэдээллээр хангаж ажиллаж байна. 32 төрлийн мэдээг E health, hinfo-3, цахим эрүүл мэнд, E hospital, E-clinic программуудыг ашиглан нэгтгэн, хянаж ЭМХТ, ЭМЯ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангана. | | | | | руу сар бүр тайлагнан ажиллаж байна.<br>- Дархан-Уул аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 3 сум, 5 өрхийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн ортой 11, үүдэн 57 эмнэлэг, 65 эмийн сангаас мэдээг утасаар болон цаасаар авч нэгтгэн мэдээний үнэн зөв байдал, чанарт хяналт, цахим эрүүл мэнд, болон hinfo-3 програмтай тулгалт хийж сар бүрийн 3-ны дотор эрүүл мэндийн хөгжлийн төв, эрүүл мэндийн газрын дарга, хэлтэс төвийн дарга нарт болон аймгийн удирлагуудад мэдээллийг цаг тухай бүрт хүргэж ажилласан. | |
| 7.1.4 | Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагуудыг өндөр хурдны интернетийн шилэн кабель, эрүүл мэндийн салбарын нэгдсэн VPN сүлжээнд холбоно. | - | VPN сүлжээнд холбогдсон ЭМБ | -4 | 2 | 5 өрх, 3 сумын эрүүл мэндийн байгууллагуудаас 6 байгууллага нь Юнивишн, 2 нь Мобинет ХХК-ийн dedicated 5mb хурдтай өндөр хурдны шилэн кабелийн интернетийн сүлжээнд холбогдсон. Интернетийн хурд сайжирснаар өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн цахим програмуудыг өндөр хурдны интернетийн сүлжээгээр ашиглаж, иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэн, мэдээ мэдээллийн тасралтгүй байдлыг хангаН ажилласан. “Шилэн эмнэлэг” /“Цахим Монгол” ЗГ-ын мөрийн хөтөлбөр/ төслийг өрх болон сумын эрүүл мэндийн төвүүдэд хэрэгжүүлэхээр Найрамдал Дархан төслийн хүрээнд ICT группээс 5 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд цаг авах тоног төхөөрөмж киоск, дэлгэцийн хамт суурилуулж иргэдэд цаг олгож байна. | 90 |
| 7.1.5 | Нэгдсэн эмнэлэг, эрүүл | - | -E-Health | -58 | Сургал | H-INFO-3 болон Е –Health программын тусламж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн төвүүдэд ашиглагдаж байгаа эмнэлзүйн “E-Health”, “E-Hospital” программ хангамжийн ашиглалтыг сайжруулж үйл ажиллагааг жигдрүүлнэ. | | программ ашиглалт<br>-<br>Сургалтад хамрагдсан мэргэжилтэн | | тад хамрагдсан мэргэжилтэн 60 | үйлчилгээний чиглэл бүрээр шинэчлэл хөгжүүлэлтийг хийж Ehealth программын модуль 90 хувьтай цахимжсан. Лабораторийн тоног төхөөрөмж URISED, BS mindray 230, Cobas e311, e411- HS70A, LanmageAE01, LanmageWS 7 төрлийн аппаратыг Ehealth программд холбогдсон. Нэгдсэн эмнэлэгт ашиглагдаж байгаа эмнэл зүйн “E-Health”, программ хангамжийн ашиглалтыг сайжруулж үйл ажиллагааг жигдрүүлэх чиглэлээр тасаг нэгжүүдээс 3045 дуудлага авч 593 нэр төрлийн шинжилгээнүүдийг тус бүрийн кодын тохируулгыг хийж ЭМД-ын системд нэгдсэн нэг нэршилтэй болсон. “E-Health”, программд 15 шинэ үйлчилгээнүүдийг үүсгэж, ажлын байраны сургалтыг 7 удаа давхардсан тоогоор 480 эмч, сувилагч нарт орсон. | |
| **Чиглэл 7<br>1-р зорилт, 5 арга хэмжээний дундаж** | | | | | | | **98** |
| **Зорилт 7.2 Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн үзүүлэлтийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох чадавхийг бэхжүүлэх.** | | | | | | | |
| 7.2.1 | Эрүүл мэндийн ажилтны статитистик мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ашиглах чадавхийг бэхжүүлнэ. | 200 мян | -<br>Сургалтад хамрагдсан ажилтны тоо | 151 | 150 | Эрүүл мэндийн байгууллагын статистик бүртгэл, мэдээллийг үнэн зөв, бодитой, хүн амд хүртээмжтэй, чанартай, шуурхай ил тод болгоход дүн бүртгэлийн ажилтнуудын чадвар, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2 удаа ЭМБ-уудын дүн бүртгэл хариуцсан 65 ажилтан сургалтад хамрагдсан.<br>-Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан Zoom сургалтад цаг тухай бүрт оролцож шинэ мэдээ мэдээллийг авч өдрийн тутмын мэдээ тайландаа хэрэгжүүлж ажиллаж байна.<br>-Өрх, сумын эрүүл мэндийн төвд шинээр хэрэгжүүлж байгаа хүүхдийн эрт илрүүлгийн үзлэг шивэх /vhs.gov.mn/ програмд нийт 42 их эмчид эрх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нээж өгч эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зарласан Zoom сургалтанд 2 удаа 48 ажилтан хамрагдаж, үзлэгийн нөхөн шивэлтийг хийсэн.<br>Сар бүр статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, ЭМГ-ын шуурхай хуралд танилцуулж байна.<br>2023 оны 11 сарын байдлаар нялхасын эндэгдлийн түвшин11 сарын байдлаар 8.2 промель байгаа нь урьд оноос 2.3 промелиор нялхасын эндэгдэл буурсан, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин11 сарын байдлаар 10.3 промель байгаа нь урьд оноос 3.2 промелиор хүүхдийн эндэгдэл буурсан, эхийн эндэгдэлгүй гаргаагүй, 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт 78.9% буюу улсын дунджаас 27.2%-иар хамрагдалт их, 18 дээш насны хамрагдалтын хувь 22.8% өмнөх оноос 14.8%-иар нэмэгдсэн, нас баралтын ерөнхий коэффицент 4.3‰ болж буурсан үзүүлэлттэй байна. | |
| 7.2.2 | Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангана. | - | Сар бүр тогтмол мэдээ өгдөг ЭМБ | 86% | 90% | Дархан-Уул аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 3 сум, 5 өрхийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн ортой 11, үүдэн 57 эмнэлэг, 65 эмийн сангаас мэдээг утсаар болон цаасаар авч нэгтгэн мэдээний үнэн зөв байдал, чанарт хяналт, цахим эрүүл мэнд, болон hinfo-3 програмтай тулгалт хийж сар бүрийн 3-ны дотор эрүүл мэндийн хөгжлийн төвд илгээж, эрүүл мэндийн газрын дарга, хэлтэс төвийн дарга, аймгийн удирлагуудад мэдээллийг цаг тухай бүрт хүргэж ажилласан. Сар бүр тогтмол мэдээ өгдөг 151 эрүүл мэндийн байгууллагын хугацаандаа мэдээ өгөлт 95% байна | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.2.3 | Эмнэлгийн мэргэжилтний судалгааны ажлыг хөгжүүлэхийг дэмжиж ажиллана. | 1 сая | -Эмч, эмнэлгийн мэргэжилтний эрдэм шинжилгээний хурал | 2 | 2 | Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан “Ёс зүй, хариуцлагыг сайжруулъя” эрдэм шинжилгээний бага хурлыг 2 үе шаттай АШУҮИС-ын Дархан салбар сургуультай хамтран зохион байгуулсан. Нийт 10 судалгааны ажилд 41 эмч нар хамтран оролцсон ба шалгарсан судлаач эмч нарыг сарын цалингийн 15-30%-иар урамшуулсан.<br><br>Нэгдсэн эмнэлэг нь эмч мэргэжилтний эрдмийн ажлыг дэмжих, судлаач сэтгэлгээг хөгжүүлэх, нотолгоонд суурилсан эмнэлзүйн мэдлэг ур чадварыг хөгжүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор “Эрдмийн чуулган-2023” болон “Эмнэлзүйн ховор тохиолдлууд-2023” хуралдааныг зохион байгуулсан. нийт 43 эмч мэргэжилтэн хамрагдаж, эрдэм шинжилгээ судалгааны өгүүлэл-3, ховор тохиолдол-15, нийт 18 бүтээл хэлэлцүүлсэн.<br><br>Дүрс оношилгооны эмч Д.Ариунболд БНСУ-ын Эрүүл мэндийн салбарын өдөрлөгт илтгэл тавьж, мэргэшил дээшлүүлэх эрхээр шагнуулсан. Дотрын их эмч Ц.Энхчимэг БНСУ-д гастроэнтерологийн хуралд ханын илтгэл, БНСУ-ийн зүрхний нийгэмлэгийн хуралд Б.Мөнхбат, С.Оргил, Ц.Энхчимэг нар ховор тохиолдлын илтгэлээр тус тус оролцсон. “Сувилахуйн технологи-2023 ” шинэ бүтээлийн үзэсгэлэнг зохион байгуулж, 16 багийн 40 гаруй бүтээлүүдийг дэлгэн танилцуулсан бөгөөд шалгарсан 16 бүтээлд батламж олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сувилахуйн хөгжил-2023”, “Нийгмийн эрүүл мэндэд сувилагчийн оролцоо” эрдэм шинжилгээний хурал болон цахим хурлыг зохион байгуулж, 16 багийн 76 судлаач сувилагч оролцон материал ирүүлснээс 16 бүтээлийг шалгаруулсан.<br>**Үр дүн:** Нийт 6 удаагийн эрдэм шинжилгээний хуралд давхардсан тоогоор 164 эмч, мэргэжилтэн оролцсон байна. | |
| **2-р зорилт, 3 арга хэмжээний дундаж** | | | | | | | 98.3 |
| **Зорилт 7.3. Хувь хүн, байгууллага, эрүүл мэндийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах** | | | | | | | |
| 7.3.1 | Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн аюулгүй байдлын 4 багц хууль (Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль)-ийг чандлан мөрдөж эрүүл мэндийн ажилтнуудад тухайн чиглэлээр тасралтгүй сургалт зохион байгуулна. | 100.0 мян | Сургалтад хамрагдсан ажилтны тоо | 151 | 155 | -Аймгийн тагнуулын газартай хамтран 2 удаагийн сургалтыг “Төрийн болон байгууллагын нууцын тухай хууль”, “Кибер аюулгүй байдлын тухай” зохион байгуулж 69 эрүүл мэндийн байгууллагын удирдлага, албан хаагчид хамрагдсан.<br>-Цагдаагийн газартай хамтран “Цахим орчин дах гэмт хэрэг” “Кибер аюулгүй ажиллагаа, урдчилан сэргийлэх” сэдвүүдийн хүрээнд сургалтад эрүүл мэндийн газрын 41 албан хаагч хамрагдсан.<br>-Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдын тоон гарын үсэг буюу цахим гарын үсэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ЭМБ-ын 390 ажилтан хамрагдсан. | 100 |
| 7.3.2 | Гэмт хэрэг, зөрчилөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна. | 100.0 мян | Сургалтад хамрагдсан | 228 | 250 | -Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2 арга хэмжээ 15 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажилтны тоо | | | -Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хүрээнд Эрүүл мэндийн газрын нууцын журам, танилцах албан тушаалтан, нууцын жагсаалтыг боловсруулан ЭМГ-ын даргын А/36 дугаар тушаалаар батлуулсан. Цахим гэмт хэрэг буюу байгууллагын цахим орчны нууц сэдэвт сургалтыг зохион байгуулж 17 албан хаагчид хамрагдсан. Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглаж байгаа 371 эмч, мэргэжилтний комюьптерыг журмын дагуу 2 удаа коджуулж шинэчилсэн.<br><br>Гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажлын хүрээнд ЭМБ-уудад нийт 157 ш камер байршуулан ажиллаж байна. | |
| 7.3.3 | Жендерийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана | - | Хэрэгжилийн хувь | 93.8 | 94 | Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/17 тоот тушаалаар "Эрүүл мэндийн салбарт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх Жендэр клуб байгуулах, журам болон төлөвлөгөө"-г батлуулсан. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд зохион байгуулах ажлын 2023-2024 оны төлөвлөгөөг 4 зорилт, 23 арга хэмжээг хэрэгжүүлэн хөтөлбөрийн хэрэгжилт 80% байна.<br>Эрүүл мэндийн салбарын бүх түвшинд ажиллагсдын жендэрийн мэдлэг, хандлага, чадварыг дээшлүүлэн мэргэшүүлж, жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэхээр Нэгдсэн эмнэлэг, ӨСЭМТөвийн удирдлага, нийгмийн ажилтан 18 хүнд ЭМСайдын 2021 оны А/625 тушаалыг танилцуулсан. Жендэрийн үндэсний | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хорооноос төвийн бүсийн 5 аймгийн хэмжээнд "Жендэр ба бодлого төлөвлөлт" чиглэлээр "сургагч багш" бэлтгэх танхимын сургалтад 1 удирдах ажилтан хамрагдсан.<br>Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11.3 дугаар зүйлд заасан чиг үүргийн хүрээнд: Ажил олгогч ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаар чиглэсэн сургалт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж хэрэгжүүлэн ажилласан. Жендерийн эрх тэгш байдлыг хангах үүднээс 26 ажилтан шинээр ажилд орсон ажилтнуудад ажлын байрны дарамт, шинэ ажилтныг гадуурхан тохуурхах түүнийг үл тэвчих хууль зүйн зохицуулалтын талаар сургалтыг явуулсан. | |
| 7.3.4 | Эрүүл мэндийн байгууллагуудад ХАБЭА-н сарын аяныг өрнүүлж, ажиллах таатай орчин нөхцлийг (гадаад, дотоод) бүрдүүлж ажиллана . | 10 сая | зохион байгуулсан үйл ажиллагаа | 10 | 10 | ХАБЭА чиглэлээр 10 төрлийн арга хэмжээг төлөвлөн хэрэгжилт 90%-тай байна.Үүнд: ОБГ-аас ЭМГ-ын барилгад үйл ажиллагаа эрхлэж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, харуул хамгаалалтын ажилтнуудад “Галын аюулгүй байдал, галын хор хэрхэн хэрэглэх” тухай сургалтад 26 хүн хамрагдаж, галын гидрантын хошуут 3 ширхэгийг сольсон. Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос Ажлын байрны стресс, менежмент сэдэвт сургалтад ЭМГ-ын 37 албан хаагч хамрагдсан. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд Эрүүл мэндийн албаны бие бүрэлдэхүүнийг хамгаалах хэрэгслээр хангахад 4.095.000 төг | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарцуулсан.<br><br>Эрүүл мэндийн газрын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд 2 удаа ажлын хэсэгт ажиллаж НЭ, Өрх, СЭМТ-үүдэд өвөлжилтийн бэлтгэл бэлэнд газар дээр үзлэг зохион байгуулж, үүрэг чиглэл өгч ажилласан. ЭМБ-уудын өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлын хэрэгжилтийн тайланг АЗДТГ-ын Захирагчийн албанд хүргүүлж ажилласан. Өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг хангах ажил 91.7%.<br><br>Эрүүл мэндийн газрын албан хаагчдын ХАБЭА-н ажлын байранд мөрдөгдөх нийтлэг зааварчилгааг боловсруулан батлуулсан. | |
| 7.3.5 | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангана | - | Хэрэгжилийн хувь | 90 | 92 | -Эрүүл мэндийн салбар нь Авлигын эсрэг үйл ажиллгааны 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 арга хэмжээ 16 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн ЭМС-ын 2/878 албан тоотын дагуу төлөвлгөөнд тодотгол хийсэн.<br><br>-Аймгийн Засаг даргын тамгын газар Хууль зүйн хэлтэсээс зохион байгуулсан “2022 оны Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахад анхаарах асуудал” цахим сургалт зохион байгуулж сургалтад 25 эмнэлгийн мэргэжилтэн, Төрийн албаны салбар зөвлөлөөс Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцаа, төрийн албан хаагчдад хүлээлгэх сахилга хариуцлага | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэдэвт сургалтад 48 албан хаагч, УИХ-ийн тамгын газар, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Нийгмийн даатгалын багц хууль”, “Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт”, “Авлигын үндэсний хөтөлбөр-(2023-2030), боловсролын тухай хуулийн сургалтанд 29 албан хаагч, ЭМГ-аас Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 5 өрхийн 98 эмнэлгийн хамрагдсан байна. Аймгийн хууль зүйн хэлтэсээс зохион байгуулсан Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтад ЭМБ-ын 50 албан хаагч хамрагдсан. Мөн АЗДТГ, ХЗХ, НБХ-ээс хамтран зохион байгуулсан “Давжээ” тэмцээнд ЭМГ-ын албан хаагчид оролцож III-р байр эзэлсэн байна.<br><br>ХАСХОМ мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн гаргаж, мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан тайлан АЗДТГ ХЗХ-т хүргүүлсэн.<br>-Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй “Нэгдье” аянд нэгдсэн. | |
| 7.3.6 | Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд ирүүлэх өргөдөл гомдлыг цахим | - | Цахимаар авч шийдвэрл эсэн | - | Өргөдө л гомдлы н 30- | Нийт эрүүл мэндийн байгууллагуудад ирүүлсэн өргөдөл гомдлын тоо 1247 байна. Үүнээс<br><br>• Санал -45 буюу 4.2% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлбэрээр хүлээн авах үйл ажиллагааг эхлүүлнэ | | өргөдөл, гомдол | | аас доошгүй хувийг цахимаар авах | • Гомдол -70 буюу 5.6%<br>• Хүсэлт -1124 буюу 90.1% -ийг эзэлж байна.<br>Ирсэн өргөдөл, санал, хүсэлтийг цаг хугацаанд нь 100% шийдвэрлэж хариуг нь бичгээр болон утсаар цахимаар мэдэгдэж асуудлыг шийдвэрлэсэн.<br>11-11өвийн гомдол санал гомдол хүлээн авах утсанд ирсэн өргөдлийн тоо -19. Үүнээс:<br>➢ Талархал -1<br>➢ Эмчилгээ үйлчилгээтэй холбоотой -14<br>➢ ЁС зүйтэй холбоотой -4 гомдол ирснийг хобогдох Эрүүл мэндийн байгууллагад нь шилжүүлж гомдлыг шийдвэрлэж аймгийн Нийгмийн бодлогын хэлтэст уламжилсан. | |
| **Чиглэл 7<br>3-р зорилт, 14 арга хэмжээний дундаж** | | | | | | | **96.6** |
| **Чиглэл 7<br>3 зорилт, 22 арга хэмжээний дундаж** | | | | | | | 97.6 |
| **Чиглэл 8. Эрүүл мэндийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгон, ил тод байдлыг дэмжиж ажиллана.** | | | | | | | |
| **Зорилт 8.1. Эрүүл мэндийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангаж, хамтын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 8.1.1 | Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулж эмнэлгийн ачаалал хуваалцах, тусламж үйлчилгээний тасралтгүй, шуурхай | - | -гэрээ байгуулан ажилласан эмнэлэг<br>-Ачаалал хуваалцсан хувь | -12 ортой эмнэлэг -50% | 12 эмнэлэг 50% | Нийт үзлэг 661172 үүнээс хувийн хэвшлийн эмнэлгийн үзлэг 126284 буюу 19.1%-ийг эзлэж байна. Нийт амбулаторийн үзлэг 330040, үүнээс ХХЭМБ-ын амбулаторийн үзлэг 119142 буюу 36%, нийт лабораторийн шинжилгээ 216352 үүнээс хувийн 8 лаборатори нийт 37222 (17.2%) шинжилгээ хийгдсэн байна. Аймгийн хэмжээнд эмнэлэгт хэвтэж тусламж үйлчилгээ авсан 27931 үүнээс хувийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртээмжтэй байдлыг ханган үр дүнг тооцож ажиллана | | | | | хэвшлийн эмнэлэгт хэвтсэн 11191 буюу 40.1% байна. Хувийн хэвшлийн шүдний үзлэг 52100 буюу нийт(73670) шүдний үзлэгийн 70.7%, эмэгтэйчүүдийн үзлэг 8116 буюу нийт (30472) эмэгтэйчүүдийн үзлэгийн 26.6%-ийг ээлж эмнэлгийн ачаалал хуваалцах, тусламж үйлчилгээний тасралтгүй, шуурхай хүртээмжтэй байдлыг ханган ажилласан байна. | |
| 8.1.2 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангана.<br>-Хүний нөөцийн<br>-Үйл ажиллагааны<br>-Төсөв, санхүүгийн<br>-Мэдээллийн | - | -<br>Мэдээлэл тавигдсан байдал<br>-<br>Хэрэгжилтийн хувь | -<br>Хэрэгжилтийн хувь 93% | Хэрэгжилтийн хувь 95% | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хэрэгжилт 95.8%-тай байна.<br><br>-Хүний нөөцийн ил тод, нээлттэй байдлыг хэрэгжилт 90%<br>-Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хэрэгжилт 95%<br>-Төсөв, санхүү, шилэн дансны ил тод, нээлттэй байдлыг хэрэгжилт 98.4%<br>-Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хэрэгжилт 100% | 95 |
| 8.1.3 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэн, төрийн бус байгууллагын Нийгмийн эгэх хариуцлагыг оролцоог нэмэгдүүлж ажиллана. | - | Хамтран ажилласан ТББ | 9 | 10 | АЗДТГ, ХХҮГ, ЭМГ, ХБХ-ийн эцэг эхийн холбоо, ТББ, Эрхэм нандин сувд ТББ, Аутизмын холбоо ТББ хамтран УБ хотын ЭХЭМҮТ-ийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношлогоонд нийт 81 хүүхдийг хамруулсан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо хамтран "PURPLE DAY " буюу эпилепситэй хүмүүсийн талаар мэдлэг ойлголт нэмэгдүүлэх өдөрлөг зохион байгуулсан.<br>Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газраас орон нутгийн "Гэр бүлийн радио" 104,5 FM-тэй хамтран "Онцгой байдлын цаг" нэвтрүүлгийн шинэ дугаарыг "Ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх" сэдвээр иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ЭСИТ ТББ-аас улсын хэмжээнд “ Халдварт өвчин ба ялган оношлогоо” сургалт зохион байгуулж хүүхдийн эмч нар оролцсон.<br>“Virtue Foundation” ОУБ-аас Нүд, Чих хамар, хоолой, Элэг цөсний мэс заслын чиглэлээр 7 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж Чих хамар хоолойн эмчийн үзлэг 16 хүнд хийж мэс ажилбар 3 хүнд, Нүдний эмчийн үзлэг 15 хүнд хийж хагалгаа 2 хүнд хийсэн.<br>БШУГ хамтран ЕБС-ийн 4-12-р ангийн сурагчид болон эрүүл мэндийн хичээлийн багш нарын дунд “Эрүүл аж төрөхүй“ уламжлалт олимпиадыг зохион байгуулж 888 сурагч, 68 багш идэвхтэй оролцсон байна.<br>АШЭМБ-ууд ГБХЗГ, ЦЕГ, Дезерит ОУБ, Монфа ЭХНБ, Монголын гэр бүл хөгжлийн нийгэмлэг, Шарын гол ХК, Тулга сувилалтай хамтран ажилласан байна.<br>Сүрьеэгийн зорилтот болон эрсдэлт бүлэгт “Уушигны эмгэгийг эрт илрүүлэх үзлэг”-ийг зохион байгуулж ӨЭМТөвүүдийн хамрагдвал зохих 1200 зорилтот болон эрсдэлт бүлгийн хүн амаас 1199 буюу **99,9 %** хамрагдаж 5 сүрьеэг, СЭМТ-ийн 1170 хүн хамрагдахаас 1211 буюу 103,5 % хамрагдаж 13 сүрьеэг , Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн хүрээнд АЗДТГ, МСЭМХ, ЭМГ-ын хамтарсан 3 талт гэрээний дагуу СЭМТөвүүдийн “Сүрьеэгээр өвдөх эрсдэлт бүлгийн хүн амд эрүүл мэндийн цогц үзлэг” -т 200 хүн хамрагдахаас 239 /119%/ хамруулан 3 сүрьеэг, ХХҮГ-тай хамтран 2 удаа Орон гэргүй, тэнэмэл, архины хамааралтай 62 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэдэд үзлэг хийн 2 сүрьеэг илрүүлэн эмчилгээ хяналтанд авсан.<br><br>“Залуус эрүүл мэнд” ЭБЭ, Төгс бүсгүйчүүд ЭБҮ-ийн ТТБ-тай хамтран шинэ бүртгэл судалгааг гаргасан. /Нууцлалттай кодтой/<br>ХӨСҮТ, “Залуус эрүүл мэнд” ТТБ-тай хамтран шинэ олон нийт болох нийт 14 ЭБЭ-д танхимын сургалтыг зохион байгуулсан. | |
| 8.1.4 | Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагын асуудлыг шийдвэрлэн ажиллаж, цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг эхлүүлнэ | 3 сая | -Захирамжийн тоо<br>-ААНБ тоо | Захирамж-4<br>Байгууллага-52 | Захирамж 4<br>Байгууллага 30 | Тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүнийг ЭМГ-ын даргын А/72 дугаар тушаал, ажлын албыг А/62 дугаар тушаалаар томилгоожуулсан. ЭМГ-ын Тусгай зөвшөөрлийн комисст ажиллах шинжээч шалгаруулах зарыг байршуулсан. Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох комиссын 7 гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх мэдэгдлийг шилэн данс болон Meduuleg.jaac.mn сайтад шивж байршуулсан. Эрүүл мэндийн газрын цахим сайтад тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн баримт бичиг, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтын байршуулсан. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахим шилжүүлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрчилгээг цахим сан үүсгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. Эрүүл мэндийн газрын вейб хуудсанд Тусгай зөвшөөрлийн хурлын шийдвэр болон гарсан тушаал шийдварийн тухай бүрт байршуулсан байна.<br>1. Хурлын шийдвэр-3<br>2. ЭМС-ийн тушаал-3<br>3. ЭМГ-даргын тушаал-3<br>4. Бүрдүүлэх материалын жагсаалт-1 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох комисс 3 удаа хуралдаж 19 байгууллагын ирүүлсэн хүсэлт, материалтай танилцан шийдвэрлэсэн байна. Үүнд: Сунгасан 8, түр түтгэлзүүлсэн 2, байрлал сольсон 4, олгосон 5<br><br>Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг томилогдон тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сангуудад дэмжлэгт хяналт үнэлгээг 37 эмийн санд хийж, 11 төрлийн зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Ортой 12 ХХЭМБ-д хяналт үнэлгээ хийж, 14 төрлийн зөвлөмж өгч ажилласан байна. | |
| 8.1.5 | Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, мэргэжлийн удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлнэ | 1 сая | -Өгсөн зөвлөмж<br>-Хэрэгжилтийн хувь | ХШҮ 4 удаа хийсэн 26 төрлийн зөвлөмж Хэрэгжилт 94.6% | ХШҮ 4 удаа зөвлөмж Хэрэгжилт 95% | Өрх, сум, нэгдсэн эмнэлгийн ХШҮ-ний жилийн дундаж хувь: 85.7%<br><br>**<u>ӨЭМТ-ийн дундаж</u>: 88.6%,** /Аминхолбоо-87.7% , Гэрэлтэй-90.3%, Госхот – 90% , Мэдстоб-88.4%, Түвшинхолбоо-86.6% /<br><br>**<u>СЭМТ-ийн дундаж</u>: 80.6 %,** /Шарын гол сум-81.7% , Хонгор сум-83.9 % , Орхон сум-76.1% /<br><br>**<u>Нэгдсэн эмнэлэг</u>: 87.9 %,**<br><br>Зөвлөмжийн хэрэгжилт 90.5%-тай байна. | 90 |
| 8.1.6 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг шийдвэрлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар комиссын үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | - | -Хурлын тоо<br>-хамрагдсан хүүхэд | 20 удаа хуралдаж 347 хүүхдийн асуудлыг 100% | -Хурал 20 удаа<br>-Шийдвэрлэлт гүйцэтгэлээр | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг шийдвэрлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар комисс 22 удаагийн хурлаар 355 хүүхдийн эрүүл мэндийн болон халамж асаргааг шийдвэрлэж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шийдвэрлэсэн. | | | |
| **Чиглэл 8<br>1-р зорилт, 6 арга хэмжээний дундаж** | | | | | | | **92.5** |
| **Зорилт 8.2. Эрүүл мэндийн байгууллагуудад өргөтгөл, засвар үйлчилгээ хийх, орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх** | | | | | | | |
| 8.2.1 | Сумын эрүүл мэндийн төвийн байр ашиглалт, урсгал засварын зардлыг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. | 25 сая | -Урсгал засвар хийгдсэн ЭМБ-ын тасаг нэгжийн тоо | 8 тасаг нэгж | Шарын гол СЭМТ | Орон нутгийн 2023 оны төсөвт сумын эрүүл мэндийн төвийн тогтмол зардалд 486.6 сая, байр ашиглалттай холбоотой урсгал засварын зардалд 18.8 сая, нийт 505.4 сая төгрөгийн төсөв батлагдсан ба хуваарийн дагуу санхүүжилт олгогдож байна. Үүнд: Шарын гол СЭМТ-ийн тогтмол зардалд 370.3 сая, байр ашиглалттай холбоотой урсгал засварын зардалд 8.6 сая, нийт 378.9 сая төгрөг, Хонгор СЭМТ-ийн тогтмол зардалд 53.1 сая, байр ашиглалттай холбоотой урсгал засварын зардалд 5.6 сая, нийт 58.7 сая төгрөг, Орхон СЭМТ-ийн тогтмол зардалд 63.2 сая, байр ашиглалттай холбоотой урсгал засварын зардалд 4.6 сая, нийт 67.8 сая төгрөгийн төсөв батлагдсан. | 100 |
| 8.2.2 | Орон нутагт зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт (тоног төхөөрөмж) бусад дэмжлэгийг аймгийн Засаг дарын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас | - | Хөрөнгө оруулалтын хэмжээ | 1,1 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн | Эмэгтэйчүүдийн дуран | Эрүүл мэндийн технологийн төлөвлөлт хийж шаардлагатай тоног төхөөрөмжийн хүртээмжийг сайжруулах зорилгоор 2023 оны жилийн эцсийн байдлаар Шинээр ирсэн тоног төхөөрөмж- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөх ор-1ширхэг 16,000,000төгрөг өртөг бүхий ОНХсан төсөлөөр Регтус ХХК нийлүүлсэн. тендер зарлаж Онош зүйн тасагт автоклав аппарат - | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана. | | | | | 1ширхэг 11,000,000төгрөгөөр, Зөөврийн кварц -1ш 280,000төгрөг, Урологийн дурангийн багаж 24,555,000төгрөгөөр авсан. Хандиваар шарын голын хандиваар каталок 4ширхэг -19,400,000төгрөг таазны гэрэл 1ширэхг 29,990,000төгрөг . Дэзэрэт олон улсын энэрлийн байгууллага хандиваар Доплер-1, биллиметр-1, нярайн жин-1 Норкозын аппарат 1ш 12.980.000төгрөг, Мэс заслын ор 2ш 22,800,000төг, Хагалгааны гэрэл 2ш 25.960.000төгрөг. Чихрийн шижингийн ретинопатийн тусламж үйлчилгээний загвар бий болгох Хөлний хүндрүл шалгах иж бүрдэл-1 850,000төгрөг , Компьютер-1 1,996,400төгрөг , Глюкогемоглобин анализатор-1 8,550,000төгрөг. Улаан загалмайн нийгэмлэг чихрийн шижингийн үеийн нүдний тонометр 1ширхэг духны гэрэл 1ширхэг 20,000,000төгрөг, аппарат хандивлав. Монфа трейд" ХХК-аас ЭМГ-аас хүчилтөрөгч өтгөрүүлэгч-1ш,пульсоксиметр 14ш хандивласан.нийт шинэ тоног төхөөрөмжийн үнэ- 205,328,885.02 төгрөг. Засварлагдсан тоног төхөөрөмж нийт -20нэр төрлийн 34,135,803 төгрөг сэлбэг авч засварласан байна. - | |
| 8.2.3 | Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим | 2 сая | Цахилгааны нөөц үүсгэвэр | 10 | 10 | Цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг ханган Төрийн Эрүүл мэндийн 10 байгууллагууд бүгд цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдал хангагдсан ба шатахууны зориулалтын саваар нөөц | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллана. | | | | | бүрдүүлсэн. | |
| 8.2.4 | Гадаад дотоодын төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг дэмжиж хамтран ажиллана. | - | - Хэрэгжсэн төсөл хөтөлбөр, үр дүн | 1 (ДЭМБ) | 1 | Монпэн ХБӨ/Зүрх судасны өвчний эрсдлийн үнэлгээнд 62372 хүн хамрагдахаас 44126 хүн хамрдагдаж, хамрагдалт 70.7%.<br>Эрсдлийн үнэлгээнд 44126 хүн хамрагдаж, ЗСӨ-тэй 747 хүн илэрсэн (1.6%) байна. Илэрсэн өвчлөлөөс 747 хүн (100%) эмчлэгдсэн байна. ЗСӨ -ний эрсдэл нь 30% ба түүнээс дээш хүмүүсийн хяналтын түвшин 0.3% байна.<br><br>Нэгдсэн эмнэлэгт Дэзэрэт олон улсын энэрлийн байгууллага хандиваар Доплер-1, биллиметр-1, нярайн жин-1 Норкозын аппарат 1ш 12.980.000төгрөг, Мэс заслын ор 2ш 22,800,000төг, Хагалгааны гэрэл 2ш 25.960.000төгрөг. Чихрийн шижингийн ретинопатийн тусламж үйлчилгээний загвар бий болгох Хөлний хүндрэл шалгах иж бүрдэл-1 850,000төгрөг , Компьютер-1 1,996,400төгрөг , Глюкогемоглобин анализатор-1 8,550,000төгрөг.<br>Улаан загалмайн нийгэмлэг чихрийн шижингийн үеийн нүдний тонометр 1ширхэг духны гэрэл 1ширхэг 20,000,000төгрөг, аппарат хандивлав. ОНХсан төсөлөөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрөх ор-1ширхэг 16,000,000төгрөг.<br>Бүх өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Дэзрэт ОУ-ын энэрэлийн байгууллага нийт 39.3 сая төгрөгийн өртөг бүхий нярайн эмчилгээний иж бүрэн багаж тоног төхөөрөмж тус бүр 1 багцыг хандтвласан байна.<br>Хонгор СЭМТ-д сумын ОНХС-аар 88,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж олгосон. Үүнд: Сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмж 41,860.0 мянган төгрөг, 38,440.0 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, компьютер, шүүгээ 8,200.0 тус тус багтсан байна. | |
| **Чиглэл 8<br>2-р зорилт, 4 арга хэмжээний дундаж** | | | | | | | **100** |
| **Чиглэл 8<br>2 зорилт, 10 арга хэмжээний дундаж** | | | | | | | **96.2** |
| **Чиглэл 9. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангаан ажиллана.** | | | | | | | |
| **Зорилт 9.1.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр шуурхай арга хэмжээ хэрэгжүүлж ажиллана.** | | | | | | | |
| 9.1.1 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, цар тахалтай тэмцэх чиглэлээр салбар дундын оролцоо бүхий багаар халдварын нөхцөл байдал, эрсдэлд тухай бүрт үнэлгээ хийж, хариу арга хэмжээний төлөвлөгөөгөө тодотгон төлөвлөгөөний | - | - Эрсдлийн үнэлгээ<br>- Төлөвлөлт хийсэн байдал<br>- Хэрэгжилт | - Эрсдлийн үнэлгээ 1 удаа “ӨНДӨР”, Ковид-оос сэргийлэх бэлэн | - Эрсдлийн үнэлгээ шаардлагатай тухай бүр хийх<br>- Төлөвлөлт | Дархан-уул аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль болохтой холбоотой Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн албаны төлөвлөгөөнд тодотгол хийж, ОБГ-аар батлуулан ажилласан.<br>Дархан уул аймгийн Засаг дарга Монгол улсын шадар сайдтай байгуулсан гэрээний дагуу 6 сарын 7-9 ний өдрүүдэд болсон “Газар хөдлөлтийн үеийн гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургууль”, 06 сарын 13-17 ны өдрүүдэд болсон “Гамшгийн эрсдлээс хамгаалах, команд штабын иж бүрэн сургууль”-д Эрүүл мэндийн алба, мэргэжлийн анги 90 хүний бүрэлдэхүүнтэй “Хээрийн эмнэлэг” | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | | | байдлын төлөвлөлт 1 удаа төлөвлөгөөний хэрэгжилт 96% | тухай бүр - Хэрэгжилт 96.5% | дэлгэн оролцож **Дүүрэн хангалттай буюу “Онц сайн”** үнэлэгдсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна. | |
| 9.1.2 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг шуурхай авах зорилгоор нөөцийн бэлэн байдлын талаарх мэдээллийн сан бүрдүүлж, тухай бүрд шаардлагатай мэдээ, мэдээллээр баяжуулж, хяналт тавина | - | | burtgel.moh.mn бүртгэл 100% | burtgel.moh.mn бүртгэл 100% | Коронавируст халдварын үеийн орны бэлэн байдлыг хангаж Халдвартын тасгийн 30 /эрчимт 4/ орны бэлэн байдлыг хангаж ажилласан.<br>ПГУ 545 хийгдсэнээс Ковидоор 245 хүн оношилогдсон байна.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 14-21 хоногийн нөөцтэй байна. ЭМЯ-д нөөцийн судалгаа гаргаж явуулсан. Burtgel.moh.mn цахимд нөөцийг 100% шивж оруулж байна. | 100 |
| 9.1.3 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын дэгдэлтийн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэвийн, тасралтгүй байдлыг хангаж, орхигдуулахгүй ажиллана. | - | Тусламж үйлчилгээ авсан иргэд | Статистик үзүүлэлтээр | Статистик үзүүлэлтээр | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын дэгдэлтийн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэвийн, тасралтгүй байдлыг хангаж Монос, Эм импекс, Мөнхийн тун, Азифарм гэх мэт нийт 25 эм хангах байгууллага, эмийн сантай гэрээтэй ажилладаг. 280 нэр төрлийн эм тарианы нөөцтэй ба 58 нэр төрлийн 23554,6 сая төгрөгийн зайлшгүй шаардлагатай эм тариа нөөцөд бэлэн байна.<br>Амбулаторийн нийт үзлэг 661172 хийгдсэн нь урьд оны мөн үеэс 19611 үзлэг нэмэгдсэн, урьдчилан сэргийлэх үзлэг нийт үзлэгийн 29.8% эзэлж байгаа нь урьд оноос 2.1%-иар нэмэгдсэн, стационариор | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 27931 хүнд хэвтэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.Нийт төрөлт 1838, амьд төрөлт 1840 байна. 1672 жирэмсэн хяналтад орсны 96.8% нь эрт буюу 0-3 сартай хяналтад орсон нь урьд оноос 2.3%-иар нэмэшдсэн сайн үзүүлэлттэй байна. Мөн нас баралт 457 тохиолдол байгаа нь урьд оны мөн үеэс 17 тохиолдлоор буурсан байна.<br><br>Ковидоор: Батлагдсан торхиолдол 245. PCR 545 хийгдсэнээс 71 эерэг буюу 13%, тест 1145 хийгдсэнээс эерэг 174 буюу 15.1%.<br>Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн 24, гэрээр эмчлэгдсэн 221 байна. | |
| 9.1.4 | Аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторит полимеразын гинжин урвал (ПГУ) шинжилгээ хийх урвалж, бодисооор тасралтгүй хангана. | 20 сая | ПГУ шинжилгээ хийсэн тоо | 5866 хүнд | Шаардлагатай тохиолдол бүрт | PCR оношлогоонд 2771 оношлуур хангагдсанаас 1043 ширхэг зарцуулж 1728 ширхэг нөөцөд үлдэгдэлтэй байна.<br>Үр дүн: Бэлэн байдлын нөөцөнд 1728 ширхэг үлдэгдэлтэй. | 100 |
| 9.1.5 | Нийт хүн ам болон зорилтот бүлэгт чиглэсэн коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулна. | 500 мян | Цахим мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо | Сургалтад 164, Мэдээлэл, сурталчилгаанд 18007 хүн | Сургалтад 200, Мэдээлэл, сурталчилгаанд 15000 хүн | Олон нутгийн DBS ТВ-ээр Короновируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар 2 удаа мэдээлэл хийж, ЭМБ-уудын цахим сайтад байршуулсан Хандалт 4800.<br>Халдварт өвчнаас сэргийлэх талаар сургалт мэдээллийг 4353 хүнд, ТВ-ийн мэдээлэл 6 удаа, цахим мэдээлэл 8 төрлөөр хийсэн байна.<br>• Амьсгалын замын халдвар, ТТӨ-өөс сэргийлэх – хандалт 1238<br>• Дархлаажуулалт гэж юу вэ?<br>• Улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах тухай – хандалт 2578 байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • ТТӨ-ий өнөөгийн нөхцөл байдал, сэргийлэх арга хэмжээ – хандалт 537<br>**Үр дүн:** Сургалт, мэдээллийг 9153 хүнд, ТВ-ийн мэдээлэл 6 удаа, цахим мэдээлэл 8 төрлөөр хийсэн байна. | |
| 9.1.6 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах, халдварын үеийн оношилгоо, эмчилгээ зэрэг сэдвээр эрүүл мэндийн ажилтнуудад тасралтгүй байдлаар “сэргээх” сургалт зохион байгуулах, сургалтад цахимаар хамрагдах боломж, нөхцлийг бүрдүүлэн ажиллана. | 2 сая | - Хамрагдсан ажилтны тоо, хувь | **461** | 200 | Халдварт өвчнөөс сэргийлэх 4 төрлийн сургалтад 90 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан. Коронавируст халдварын сэргийлэлт хяналт ажлын байран дахь сургалт 175 хүнд, улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулахтай холбоотой өрх, сумын ЭМТ-ийн удирдлага, вакцинатори, ЕБС, СӨБ-ын эмч 65 хүнд, Вакцины хүйтэн хэлхээ, аюулгүй тарилга, халдварын сэргийлэлт хяналт сургалтыг 2 удаа 16 хүнд, , Томуугийн дархлаажуулалтын сургалтыг эрүүл мэндийн 38 ажилтанд зохион байгуулсан нийт 384 ажилтан хамрагдсан.<br><br>Хэвлэл мэдээллийн хэрэгсэл орон нутгийн ТВ-ээр “Тууралтат халдварын тохиолдол, сэргийлэх арга хэмжээ” “Короновируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал”, “Дархлаажуулалт гэж юу вэ?”, “Улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” мэдээ,зөвлөмжийг хүргэсэн.<br><br>**Үр дүн:** Сургалтад 384 эмнэлгийн ажилтан хамрагдсан байна. | 100 |

| | |
|---|---|
| **Чиглэл 9<br>1 зорилт, 6 арга хэмжээний дундаж** | **95** |
| **НИЙТ ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ** | **94.6** |

Эрүүл мэндийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 чиглэл, 25 зорилт, 123 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт ***94.6%***

1 чиглэлд 4 зорилт, 29 арга хэмжээ 97.58 хувь
2 чиглэлд 8 зорилт, 38 арга хэмжээ 93.6 хувь
3 чиглэлд 3 зорилт, 11 арга хэмжээ 96 хувь
4 чиглэлд 1 зорилт, 5 арга хэмжээ 90.6 хувь
5 чиглэлд 2 зорилт, 6 арга хэмжээ 85 хувь
6 чиглэлд 1 зорилт, 4 арга хэмжээ 100 хувь
7 чиглэлд 3 зорилт, 14 арга хэмжээ 97.6 2хувь
8 чиглэлд 2 зорилт, 10 арга хэмжээ 96.2  хувь
9 чиглэлд 1 зорилт, 6 арга хэмжээ 95 хувь

Тайлан нэгтгэсэн:
ХШҮ-ний мэргэжилтэн /Ч.Мөнхцэцэг/
Тайлан ХЯНАСАН:
ХШҮМХ-ийн дарга /Б.Золбаясах/

Тайлан баталгаажуулсан:
Эрүүл мэндийн газрын дарга /Б.Батцэнгэл/

2023.12.08